ӨМНӨГОВЬ АЙМАГ
СЭВРЭЙ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 03 сарын 27 өдөр Дугаар 3/19 Сайншанд

Зөв бүхэн зөвхөн манай гэр бүлээс дэд хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дах хэсэг, 35 дугаар зүйлийн 35.1.8 дахь заалт, сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 02/04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Сумын Засаг даргын 2024-2028 онд хэрэгжүүлэх "Тогтвортой хөгжсөн Сэврэй-2028" үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд хэрэгжих "Зөв бүхэн зөвхөн манай гэр бүлээс" дэд хөтөлбөрийг нэгдүгээр хавсралтаар, хэрэгжилтийг удирдан зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийг жил бүрийн сумын хөгжлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж, хэрэгжилтийн явц үр дүнг жил бүр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж ажиллахыг сумын Засаг дарга /Б.Батсайхан/-д үүрэг болгосугай.

ДАРГА Ч.ОГТБИШ

4625013036

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн
03/19 дүгээр тогтоолын нэгдүгээр
Хавсралт

ЗӨВ БҮХЭН ЗӨВХӨН МАНАЙ ГЭР БҮЛЭЭС ДЭД ХӨТӨЛБӨР

Нэг. Хөтөлбөр боловсруулах нийтлэг үндэслэл

1.1 Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.3 дахь заалт, 20 дугаар зүйлийн 20.1.5 дахь заалт

1.2 Монгол Улсын Их хурлын 2020 оны 05 сарын 13 ны өдрийн 52 дугаар тогтоолоор батлагдсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын бичиг баримтын 2 дугаар зорилтыг хэрэгжүүлэх

1.3 Аймгийг 2024-2028 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл;

1.4 Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны "Өсөлттэй Өмнөговь" хөтөлбөрийн 2.1.1.24 , 3.3.6.2, 2.3.1.2, 2.3.1.2, 2.1.1.5 дахь заалт;

1.5 Сэврэй сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн "Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлогын өсөлт" заалтыг хэрэгжүүлэх.

Хоёр. Хэрэгцээ шаардлага

Гэр бүлийн талаарх үзэл хандлага хэвшмэл байдлаас аажмаар өөрчлөгдөх байдал ажиглагдаж байна. Ингэхдээ гэр бүлийн эрхэм нандин чанар алдагдаж, үнэнч бус байдал, материаллаг сонирхолд тулгуурлах, гэр бүлийн хариуцлагаас зайлсхийх, аминч үзэл давамгайлах хандлага бий болж байна.

Гэр бүлийн гишүүдийн хоорондын зохицол, биесээ ойлгох харилцаа, сэтгэл ханамж, сэтгэл зүйн боловсрол, зөрчил, бэрхшээлийг даван туулах арга зам зэрэг нь тэдний гэр бүлийн боловсролтой шууд холбоотой байдаг. Энэ нь нэг талаас хүүхэд залуусыг хөгжүүлж, хүмүүжүүлж, төлөвшүүлэхэд гэр бүл, эцэг, эхчүүдийн оролцоо, үлгэр дуурайл чухал байдгийг харуулж байгаа бөгөөд нөгөө талаас эцэг, эхчүүд гэр бүлийн өндөр боловсролтой байх ёстойг илэрхийлж байна.

Өсвөр үе залуучуудад тулгарч буй нийтлэг асуудал бэрхшээлийг шийдвэрлэх арга замыг эрэлхийлж, залуучуудын оролцоог нэмэгдүүлэх, залуу гэр бүлийн суурь хэрэгцээг хангахад дэмжлэг үзүүлэх, Хүүхэд, залуучууд, гэр бүлийн боловсрол, хандлага төлөвшил, эрүүл мэндийг сайжруулах, нийгмийн идэвх, оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн орон нутгийн бодлого хэрэгжүүлэх шаардлага бий болоод байна. 2021-2024 онд уг хөтөлбөрийг анхлан хэрэгжүүлсэн бөгөөд 4 жилийн хугацаанд 11 сургагч багшийг урьж төрийн албан хаагчид, Хувираа хөдөлмөр эрхлэгчид, залуу гэр бүлүүд, залуучуудад зориулсан сургалт лекцүүдийг зохион байгуулж давхардсан тоогоор 1200 иргэн хамрагдаж, "Хэрсүү гурвалжин" аян, "Сархадгүй сонголт", Тоглох орчны эрсдэл бууруулах аян, "Дэм дэмдээ", "Хайрын гар" аян, Хамтдаа шалгая, Зөв зөвд шударга зөв, Энэ жилдээ эрүүл жиндээ, Эртэч Сэврэйчүүд зэрэг аянуудыг зохион явуулж 800 гаруй иргэнийг хамруулсан. Мөн олон улсын Гэр бүлийн өдрийг 3 жил тэмдэглэн өнгөрүүлж гэр бүлийн үнэ цэнийг

нэмэгдүүлж иргэдэд эерэг нөлөөлөл үзүүлсэн хөтөлбөр болсон гэж дүгнэж уг хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх хэрэгцээ байна гэж үзсэн.

Гурав. Хамрах хүрээ

Энэхүү хөтөлбөрт тус сумын нийт гэр бүл, иргэд хамрагдана.

Дөрөв. Хөтөлбөрийн зорилго:

Хүүхэд, залуус, насанд хүрэгчид, өрхийн гишүүдийн гэр бүлийн боловсролыг дээшлүүлэх, улмаар амьдралын чанарыг сайжруулах, гэр бүлийн бат бөх, тогтвортой харилцааг бий болгох, залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, биеийн тамир спортоор хөгжүүлэх, амьдрах ухааныг хөгжүүлэх, нийгэмд хүлээх эрх үүрэг, хариуцлага оролцоог нэмэгдүүлэн, мэдлэг боловсролтой, зөв хандлагатай, зөв сэтгэлгээтэй иргэдийг төлөвшүүлэхэд оршино.

Тав. Хөтөлбөрийн зорилт:

5.1 Гэр бүлийн харилцаанд гарч буй өөрчлөлт, тулгамдаж буй асуудал, амьдралын хэв маягийн дэвшилтэт талыг судлан , сөрөг үр дагаврыг арилгах, эерэг үр дүнг дэмжин дэлгэрүүлэх зорилгоор гэр бүл судлалыг хөгжүүлэх, сан бүрдүүлэх

5.2 Гэр бүлийг бэхжүүлэх, өрхөд гэр бүлийн боловсрол олгох модуль сургалт, сэтгэл зүйн боловсрол олгох сургалтуудыг үе шаттай зохион байгуулж, зөвлөгөөн, уулзалт, өдөрлөг, лекц, кейс хэлэлцүүлгийг зохион байгуулах,

5.3 Оролцоотой, хариуцлагатай, зөв дадал зуршилтай, ёс суртахуунтай, эерэг хандлагатай гэр бүл, иргэдийг бий болгоход чиглэсэн арга хэмжээг зохион байгуулж залуу гэр бүл, залуучуудад чиглэсэн сургалт, урлаг спортын арга хэмжээ зохион байгуулах, улс, бүсийн чанартай тэмцээн уралдаанд хамрагдахад дэмжлэг үзүүлнэ.

5.4 Ирээдүй болсон хүүхэд залуучуудад үлгэр дуурайлал болж байгаа манлайлагч залуучууд, гэр бүл, иргэн, иргэний нийгмийн байгууллагуудыг дэмжин алдаршуулж, урамшуулахын зэрэгцээ нэрэмжит тэмцээн уралдаануудыг зохион байгуулж хэвших

Зургаа: Хөтөлбөрийн зорилтуудын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

6.1 Гэр бүлийн харилцаанд гарч буй өөрчлөлт, тулгамдаж буй асуудал, амьдралын хэв маягийн дэвшилтэт талыг судалж, сөрөг үр дагаврыг арилгах, эерэг үр дүнг дэмжин дэлгэрүүлэх зорилгоор гэр бүл судлалыг хөгжүүлэх

6.1.1 Гэр бүлүүдээс харилцаа, хандлага, амьдралын хэв маяг, тулгамдаж буй асуудал, хэрэгцээ шаардлагыг илрүүлэх төрөл бүрийн судалгаа боловсруулж, оновчтой аргаар зорилтот өрхүүдийг бүрэн хамруулж авах, судалгааны сан бүрдүүлэх

6.1.2 Судалгааны үр дүнд дүгнэлт хийж, гэр бүлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага, мэргэжилтнүүдэд танилцуулж зөвлөгөө авч ажиллах

6.1.3 Судалгааны үр дүнг ИТХ, сумын Засаг дарга, багийн Засаг дарга нар болон холбогдох мэргэжилтнүүдэд танилцуулж авах арга хэмжээ, үйл ажиллагааг төсөл, хөтөлбөрт тусгаж, зээл тусламжид хамруулах

6.2 Гэр бүлийг бэхжүүлэх, өрхөд гэр бүлийн боловсрол олгох модуль сургалт, сэтгэл зүйн боловсрол олгох сургалтуудыг үе шаттай зохион

байгуулж, зөвлөгөөн, уулзалт, өдөрлөг, лекц, кейс хэлэлцүүлгийг зохион байгуулах,

6.2.1 Судалгаанд тулгуурласан өрх гэр бүл, зорилтот бүлэгт зориулсан боловсрол олгох сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг үе шаттайгаар зохион байгуулах

6.2.2 Зорилтот өрхөд чиглэсэн "Гэр айлчлал" явуулын үйлчилгээг жилд 8 доошгүй гэр бүлд үзүүлэх

6.2.3 Гэр бүлүүдийн болзоо, уулзалт зохион байгуулж гэр бүлийн харилцаа, залуу гэр бүл, хосуудад тулгамдаж буй асуудлаар хэлэлцүүлэг хийх

6.2.4 Байгууллага, аж ахуйн нэгж бүрийн дэргэдэх эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэн, удирдлага арга зүйгээр хангаж ажиллах

6.2.5 Гэр бүлийн бат бөх харилцаа бий болгох, бие биеэ хайрлан хүндлэх, өрхийн орлого нэмэгдүүлэх, өрхийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, гэр бүлүүдийг дэмжин хөгжүүлэх чиглэлээр төрөл бүрийн арга хэмжээ зохион байгуулах

6.2.6 Гэр бүлд зориулсан нөлөөллийн арга хэмжээнүүдийг зохион байгуулах

6.2.7 "Нийгмийн салбарын нээлттэй өдөрлөг" зохион байгуулах

6.3 Оролцоотой, хариуцлагатай, зөв дадал зуршилтай, ёс суртахуунтай, эерэг хандлагатай гэр бүл, иргэдийг бий болгоход чиглэсэн арга хэмжээг зохион байгуулж залуу гэр бүл, залуучуудад чиглэсэн сургалт, урлаг спортын арга хэмжээ зохион байгуулах улс, бүсийн чанартай тэмцээн уралдаанд хамрагдахад дэмжлэг үзүүлнэ.

6.3.1 Гэрлэлтээ батлуулж буй гэр бүлийн гэрлэлтийн гэрчилгээг ёслол төгөлдөр гардуулах, мэдээлэл сургалт хийх, хосуудын хуримын ёслолыг зохион байгуулах

6.3.2 Эрүүл зан үйл төлөвшүүлэх аянуудыг өрнүүлэн, хэвшүүлэх

6.3.3 Гэр бүл, хүүхэд залуучуудад зориулсан "Сайн туршлага" цахим хуудас нээж ажиллуулах

6.3.4 Залуу гэр бүл, оюутан, залуучуудад чиглэсэн сургалт, урлаг спортын арга хэмжээ жил бүр уламжлал болгон зохион байгуулах

6.4 Ирээдүй болсон хүүхэд залуучуудад үлгэр дуурайлал болж байгаа манлайлагч залуучууд, гэр бүл иргэний, иргэний нийгмийн байгууллагуудыг дэмжин алдаршуулж, урамшуулахын зэрэгцээ төрөл бүрийн арга хэмжээ зохион байгуулж хэвших

6.4.1 Хүүхэд залуучуудад үлгэр дуурайлал болж манлайлж байгаа иргэд, гэр бүл, иргэний нийгмийн байгууллагыг алдаршуулж, урамшуулна.

6.4.2 Сум орон нутгийн нэрийг өндөрт өргөж яваа алдартны нэрэмжит тэмцээн уралдаан, хүүхэд багачуудын хөгжилд эерэг сайнаар нөлөөлөх арга хэмжээ, залуучууд, гэр бүлд эергээр нөлөөлөх бүх төрлийн нөлөөллийн арга хэмжээг дэмжин, зохион байгуулна.

6.4.3 "Хатан ээж" арга хэмжээг зохион байгуулна.

6.4.4 Хүүхэд, залуучууд, гэр бүлийн дунд урлаг, спортын арга хэмжээ зохион байгуулна.

Долоо. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ дараах зарчмыг баримтална.

7.1 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа, төлөвлөлтийг хүүхэд хамгаалал, гэр бүл, залуучуудад чиглэсэн бусад хөтөлбөрүүд, эдийн засаг, нийгэм, орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлттэй нягт уялдаатай харилцан зохицсон байдлаар хэрэгжүүлнэ.

7.2 Хөтөлбөрийн зорилго үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, иргэний нийгмийн оролцоог дэмжиж өргөнөөр оролцох, хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.

7.3 Зорилт, арга хэмжээнүүдийг аймаг, Сэврэй сумын Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрүүдэд тусган шуурхай хэрэгжүүлнэ.

Найм. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, санхүүжилт,удирдлага зохион байгуулалт

8.1. Хөтөлбөрийг 2025-2028 онуудад хэрэгжүүлнэ.

8.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны санхүүжилт дараах эх үүсвэрээс
санхүүжүүлнэ.

8.3 Орон нутгийн төсөв

8.4 Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын өөрийн хөрөнгө

8.5 Бусад эх үүсвэр

Хөтөлбөрийг удирдан зохион байгуулах, мэдээллээр хангах, хэрэгжилтэд хяналт тавих үүргийг сумын Засаг даргын Тамгын газар хариуцан, холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.

Ес. Хөтөлбөрийн үр дүн

9.1 Гэр бүл, хүүхэд, залуучууд, иргэдийн судалгааны сан бий болно.

9.2 Гэр бүл, иргэдэд зориулсан ёс зүйн боловсрол олгох, амьдрах ухааны, хувь хүний хөгжлийн сургалтууд, эерэг нөлөөлөл үзүүлэх аян, зөвлөгөөн, уулзалт, өдөрлөг, лекц, кейс хэлэлцүүлэгүүд зохион байгуулагдана.

9.3 Оролцоотой, хариуцлагатай, зөв дадал зуршилтай, ёс суртахуунтай, эерэг хандлагатай гэр бүл, иргэдийг бий болгоход чиглэсэн арга хэмжээг зохион байгуулж залуу гэр бүл залуучуудад чиглэсэн сургалт, урлаг спортын арга хэмжээнд хамрагдахад дэмжлэг үзүүлнэ.

9.4 Хойч ирээдүй болсон залуучуудын харилцаа хандлага, ёс суртахуун, бие даан амьдрах чадварт нөлөөлж, эх оронч үзэлтэй, хариуцлагатай иргэн болж төлөвшихөд нөлөөлнө.

9.5 Ирээдүй болсон хүүхэд залуучуудад үлгэр дуурайлал болж байгаа манлайлагч залуучууд, гэр бүл, иргэн, иргэний нийгмийн байгууллагуудыг дэмжин алдаршуулж, урамшуулахын зэрэгцээ нэрэмжит уралдаан тэмцээн, арга хэмжээг зохион байгуулж, хүүхэд, залуучуудыг урлаг, спортоор хөгжүүлнэ.

Арав. Хөтөлбөрийн хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээ

10.1. Сумын Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгж нь хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг нэгтгэн, сумын Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж, Иргэдийн төлөөлөгчдийн Хуралд тайлагнана.

10.2. Хөтөлбөрийн хэрэгжилт үр дүнг тооцон, иргэдэд ил тод мэдээлнэ.

Арван нэг. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт:

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Зорилтот түвшин			
			2024	2025	2026	2027	2028
	1 дүгээр зорилтын хүрээнд						
1	Гэр бүлийн чиглэлээр судалгааны сан бүрдүүлэх	тоо	5	6	6	8	8
	2 дугаар зорилтын хүрээнд						
2	Хөтөлбөрийн хүрээнд сургалтад хамрагдсан иргэд	тоо	280	400	400	400	400
3	Хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулсан аян, нөлөөллийн үйл ажиллагаанд хамрагдсан иргэд	тоо	150	250	250	250	250
4	Байгууллагын эцэг эхийн зөвлөлийн гишүүдэд сургалт хийх, зөвлөн туслах, үйл ажиллагаанд хяналт тавих	тоо	2	3	3	3	3
5	Нийгмийн салбарын нээлттэй өдөрлөг, явуулын үйлчилгээний тоог нэмэгдүүлэх	тоо	0	1	1	1	1
6	Гэр бүлийн бат бөх харилцаа бий болгох, бие биеэ хайрлан хүндлэх, өрхийн орлого нэмэгдүүлэх, өрхийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, гэр бүлүүдийг дэмжин хөгжүүлэх чиглэлээр төрөл бүрийн арга хэмжээ зохион байгуулах	тоо	3	5	5	5	5
	3 дугаар зорилтын хүрээнд						
7	Ёслол хүндэтгэлийн өргөөнд Хурмын ёслол зохион байгуулах	тоо	0	2	2	2	2
8	Эрүүл зан үйл төлөвшүүлэх арга хэмжээний тоог нэмэгдүүлэх	Тоо	2	3	3	3	3
9	“Сайн туршлага” цахим хуудас нээж ажиллуулах	Нийтлэлийн тоо	0	10	10	10	10
10	Зөв дадал зуршилтай, ёс суртахуунтай, эерэг хандлагатай гэр бүл, иргэдийг бий болгоход чиглэсэн нөлөөллийн үйл ажиллагааны тоог нэмэгдүүлэх	тоо	3	5	5	5	5
	4 дүгээр зорилтын хүрээнд						
11	“Хатан эзэж” арга хэмжээ зохион байгуулах	тоо	1	1	1	1	1
12	Сумын иргэд, хүүхэд, залуучуудын дунд урлаг, спортын өдөрлөг, арга хэмжээ зохион байгуулах	тоо	4	6	6	6	6
13	“Гэр айлчлал “ явуулын үйлчилгээ үзүүлэх	тоо	5	8	8	8	8

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн
03/19 дүгээр тогтоолын хоёрдугаар
хавсралт

ЗӨВ БҮХЭН ЗӨВХӨН МАНАЙ ГЭР БҮЛЭЭС ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ

Ажлын хэсгийн дарга: Засаг даргын Тамгын газрын дарга

Гишүүд: Б.Одгэрэл (Сумын ИТХ-ын төлөөлөгч)

Ерөнхий боловсролын сургуулийн захирал

20 дугаар цэцэрлэгийн эрхлэгч

Эрүүл мэндийн төвийн эрхлэгч

Соёлын төвийн эрхлэгч

Ахмадын хорооны дарга

Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн

Залуучууд хөгжлийн төвийн ажилтан

Хүүхэд, гэр бүлийн Нийгмийн ажилтан

Нарийн бичиг: Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын мэргэжилтэн

---000---